

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНААС 2009 ОНЫ 03 ДУГААР САРД
ХИЙСЭН ГОЛ АЖИЛ**

Нэг. Бодлого төлөвлөлтийн асуудлаар:

1. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- Хаваржилтын байдал хүндрэлтэй байгаа 6 аймгийн малчдад нөөцөд байгаа өвс, тэжээлийн үнийг 50 хувь хөнгөлж олгох асуудлыг танилцуулж, Засгийн газрын 83 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв.
- Хаваржилтын байдал хүндрэлтэй байгаатай холбогдуулан байгаль цаг агаарын гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжэний тухай Засгийн газрын 01 тоот албан даалгаврыг ОБЕГ-тай хамтарч хэрэгжилтийг зохион байгуулж байна.

2. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн асуудал:

- “Малчдын талаар төрөөс баримтлах бодлого”-ын баримт бичгийн төслийг хэлэлцүүлж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр тогтов.
- Худгийн барилга, тоног төхөөрөмжийн стандарт,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2008 оны санхүүгийн тайлангийн үр дүнг танилцуулав.

3. Судалж, боловсруулсан асуудлын талаар:

- “Тариалангийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.
- “Арьс шир” хөтөлбөрт нэмэлт оруулах тухай төслийг боловсруулж, Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.
- “Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх бүс нутагт үйл ажиллагаа явуулах журам”-ын төслийг боловсруулав.
- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр худалдан авсан нөөцийн буудайг борлуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулав.
- “Малын удмын сангийн үндэсний төвийн дүрэм батлах тухай” Засгийн газрын тогтоол болон дүрмийн төслийг боловсруулан, санал авахаар Монгол Улсын шадар сайд, салбарын сайд нарт хүргүүлэв.
- Дотоод худалдаа, үйлчилгээний дунд хугацааны үзэл баримтлал болон санхүү-эдийн засгийн хямралын үед яаралтай авч хэрэгжүүлэх ажлын саналыг тус тус боловсруулав.
- Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори болон Малын эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон тус хоёр лабораторийн ажиллах дүрмийн төслийг боловсруулан яамд, Монгол улсын шадар сайдад хүргүүлэв.
- Хүнсний этилийн спирт, төрөл бүрийн архины мэдрэхүйн шинжилгээний арга, хүнсний зориулалттай түүхий эдээс гарган авсан түүхий спиртийн техникийн шаардлагын стандартын төслүүдийг боловсруулж, ажлын хэсгийн гишүүдээс санал авахаар хүргүүлэв.
- “Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл”-ийн төслийг боловсруулж, яамны удирдлагуудад танилцуулаад байна.
- “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн төсөлд холбогдох яамдын саналыг авч, тусгаад байна.
- “Хоршоо болон бичил бизнесийг дэмжих мастер төлөвлөгөө”-ний баримт бичиг боловсруулж байна.
- “Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг шинээр байгуулан ажиллаж байна.

Хоёр. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудлаар:

- Монгол Улсад хөнгөн аж үйлдвэрийн салбар үүсч хөгжсөний 75 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Мэргэжлийн холбоодын нэгдсэн зөвлөл, Монголын үйлдвэрлэл, үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран “Гурван үеийн чуулга уулзалт”, “Ойн баярын нэгдсэн хурал”, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулав.
 - ОХУ-аас импортоор оруулж ирсэн хүнсний улаанбуудайнаас “Таван нуур”, “Хос тав”, “Барил трейд” ХХК-ны гурилын үйлдвэрүүдэд 486,0 тн-ыг борлуулж, одоогийн байдлаар нийт 6134,0 тн улаанбуудай борлуулаад байна.
 - Үрийн будаа, хор гербицид, үр бордооны захиалгыг аж ахуйн нэгжүүд болон аймгуудын ХХААГ-аас авч нэгтгэн хуваарь хийж, Сайдын тушаал гаргахад бэлэн болгоод байна.
 - Дунд оврын төмсний иж бүрдэл болон жижиг оврын тракторыг аж ахуйн нэгж, иргэдэд гэрээгээр 16 ширхэгийг олгох ажлыг зохион байгуулав.
 - Ерөнхий Сайдын ОХУ-д хийсэн айлчлалын дагуу Монгол орны хөрс, цаг уур, агротехнологийн шаардлагад нийцсэн Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн үнийг харьцуулан судалж, ОХУ-аас эхний ээлжинд авах 70,0 сая ам долларын үнэ бүхий техникийн жагсаалт, тоо хэмжээг гаргаж хүргүүлэв.
 - Малын удмын сангийн төвийг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөх, аймгуудад ажиллаж байгаа цөм сүргийн үржлийн төвүүдийг таган буулгахтай холбогдуулан холбогдох байгууллагуудын эд хөрөнгө, цөм сүргийн малд үзлэг, тооллого хийж, цаашид ажиллах чиглэлийн талаар асуудал боловсруулан шийдвэрлүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг орон нутагт ажиллуулж байна.
 - Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бүс нутгийг 2 жил өнжөөхтэй холбогдуулан нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулав.
- 2009 оны 3 дугаар сарын 10-ны байдлаар отрын нутгаас 166 өрхийн 114005 мал орон нутагтаа буцаж, одоогийн байдлаар 377 өрхийн 254982 мал хаваржиж байна.
- Отрын бүсэд өвөлжсөн нийт 150 өрхийг хүн эмнэлгийн үзлэг, үйлчилгээнд хамруулж, 8000 малд ивомек тарилга хийж, мал сүргийн хорогдлоос сэргийлэх зорилгоор 53 тонн багсармал тэжээл тээвэрлэн борлуулсан байна.
- "Сүү" үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөл бүхий зээл олгох төсөл сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулав.
 - Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хэмжээнд 2008 онд гүйцэтгэж дууссан Шинжлэх ухаан технологийн нийт 20 төслөөс 10 тайлан хүлээн аваад байна. Уг төслүүдэд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг байгуулав.

Гурав. Гадаад хамтын ажиллагаа болон дотоод ажлын талаар

- Бүгд Найрамдах Болгар Улсын Хөдөө аж ахуй, Хүнсний сайд тэргүүтэй төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн ажлын айлчлалыг зохион байгуулж, Монгол Улсын ХХААХҮЯ болон Бүгд Найрамдах Болгар Улсын ХААХЯ хооронд “Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамтран ажиллах Протокол-д гарын үсэг зурав.
- Монгол Улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн ажлын айлчлалын үеэр Монгол Улсын ХХААХҮЯ болон ОХУ-ын ХААЯ хоорондын Харилцан ойлголцлолын санамж бичигт гарын үсэг зурж, ОХУ-аас манай орны хөдөө аж ахуйн салбарт хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг шийдвэрлэв.
- НҮБ-ын ХХААБ-ын Суурин төлөөлөгчийн Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулж, ХХААХҮ-ийн сайд болон яамны холбогдох удирдлагуудтай уулзаж, “Хүнсний баталгаат байдал” хөтөлбөрийг хандивлагчдад танилцуулах, хуралдааныг зохион байгуулах болон цаашид хамтран ажиллах талаар харилцан тохиролцов. Мөн айлчлалын үеэр “Хил дамнасан малын халдварт өвчний тандан судалгаа” төслийн үйл ажиллагаатай танилцав.
- НҮБ-ын ХААХОУС-ийн Монгол дахь хөтөлбөр хариуцсан менежер болон “Байгаль орчны нөөцийн менежментийн төсөл”-ийн загвар байгуулах судалгааны багийг хүлээн авч хамтран ажиллав.
- Азийн Хөгжлийн Банкны Зүүн Азийн газрын Байгалийн нөөцийн эдийн засагчийн Монгол Улсад хийсэн айлчлалыг зохион байгуулж, “Ядуу малчин өрхүүдэд уст цэгийн хангамжийг дээшлүүлж, экстейншний үйлчилгээг нэвтрүүлэх” төслийн хэрэгжилттэй танилцав.

- Канад Улсын Бээжин дэх ЭСЯ-ны Мал эмнэлгийн асуудал хариуцсан зөвлөх Мал эмнэлэг, Ургамлын хорио цээрийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, яамд хоорондын шууд хамтын ажиллагааны Протоколыг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар оруулах талаар ажиллав.
- Атрын-III аяны хүрээнд Говь-Алтай аймгаас үйлдвэрлэгчдээс ирүүлсэн захиалгын дагуу “Хүлэмжийн аж ахуй эрхлэх” сэдэвт сургалтыг тус аймагт 03 дугаар сарын 21-23-ны хооронд зохион байгуулав.
- Хэнтий аймгийн ХААНТ-ийн захиалгаар “Газар тариаланг эрчимжүүлэх, цомхотгосон техник технологийг ашиглах” сэдэвт сургалтыг Хэнтий аймагт 03 дугаар сарын 16-18-ны хооронд зохион байгуулав.
- Дор дурдсан хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийв. Үүнд:
 - Яамны 2008 оны үйл ажиллагааны үр дүн,
 - Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 2004-2008 оны эхний үе шатны төлөвлөгөөний биелэлт,
 - “Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл” хөтөлбөр,
 - “Монголын төмсний салбарыг сэргээн сайжруулах” төсөл,
 - “Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилт
 - Засгийн газраас баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үр дүн

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ